



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/57

Булган сум

Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.3.1, 1.6.1.1, 1.6.1.6, 1.6.3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/33 дугаар хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүлэх тухай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос хурдан шуурхай, чанартай хүргэх зорилгоор "Хүрч үйлчилье" нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2."Хүрч үйлчилье" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: С.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын дарга)
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
дарга)
Ц.Энх-Амгалан (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)
Б.Ариунболд (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн
дарга)
П.Оюунцэцэг (Нэгдсэн эмнэлгийн дарга)
Б.Оюунгэрэл (Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эмч)
Б.Цогтгэрэл (Нэгдсэн эмнэлгийн ЭБЭ-ийн тасгийн эмч)
Ц.Баттулга (Нэгдсэн эмнэлгийн Амбулаторийн тасгийн
эмч)

Нарийн бичгийн дарга: Г.Баярцэцэг (Биеийн тамир спортын газрын арга зүйч)
Г.Нарантуяа (Биеийн тамир спортын газрын арга зүйч)
М.Солонго (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6330011195

3. Арга хэмжээг чанартай, хурдан шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

4. “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3,021,200 (гурван сая хорин нэгэн мянган хоёр зуу) төгрөгийг хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 20..... оны
..... дугаар сарын-ний өдрийн..... дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ "ХҮРЧ ҮЙДЧИЛБЕ" НЭГДСЭН
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт
1	2	3	4	5
1	Шатахууны зардал /5 машин 700 км/	360 л	2520	907,200
2	Хэвлэлийн зардал /хулдаасан хэвлэл 2*3 м/	3*3 м	12700	114,000
3	Хүнсний багц /гурил, будаа, тос/	40 өрх	50000	2,000,000
	Дүн			3,021,200